



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/10/

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуш модны нөөц тогтооход шаардлагатай багаж тоног төхөөрөмж болох дрон, зургийн аппарат, байршил тогтоогч, Мод үржүүлгийн газрын ажилд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай намираа усалгааны систем марганц, шланк, зэсийн байван хүлэмжийн хар тор хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Мягмардагва (Ойн инженер)

Гишүүд: Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын
нярав)


М.Батсүх (иргэдийн Хурлын Төлөөлөгч)

Х.Нямдаваа (Нөхөрлөлийн холбооны тэргүүн)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангуулж хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (А.Мягмардагва)-д даалгасугай.

3.Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлсэн Хуш модны нөөц тогтооход шаардлагатай багаж тоног төхөөрөмж дрон, зургийн аппарат, байршил тогтоогч, Мод үржүүлгийн газрын ажилд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай намираа усалгааны систем марганц, шланк, зэсийн байван хүлэмжийн хар торыг өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг сум дундын Ойн ангийн нягтлан бодогч (Д.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

20240506